



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Бараа материал шилжүүлэх,
орлогод авах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын дарга тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.4.2-ын "в", 136.5.2-ын "в" дэх заадт, Цагдаагийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын эргэлтийн хөрөнгөөс Замын цагдаагийн албанд 3 300 000.00 /гурван сая гурван зуун мянга/ төгрөгийн дансны үнэтэй суурин блокийг балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Тусгай ажиллагааны газарт ашиглагдаж данс бүртгэлд тусгагдаагүй 3 988 797.42 /гурван сая есөн зуун наян найман мянга долоон зуун ерэн долоон төгрөг дөчин хоёр мөнгө/ төгрөгийн үнэ бүхий /Автомат буу Bren 805 A1/ галт зэвсгийн дагалдах хэрэгслийг Санхүү, аж ахуйн албаны дансанд авч, бүртгэлийг хөтөлсүгэй.
3. Эд хөрөнгийг шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, данс бүртгэлээс хасахыг Автобаазын дарга /цагдаагийн хурандаа / Ү.Зоригтбаатар/-д, орлогод авч данс бүртгэлд тусгахыг Замын цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа /Б.Даваазул/-д, Тусгай ажиллагааны газрын хөрөнгийг данс бүртгэлд тусгахыг Санхүүгийн Хэлтсийн ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахлах дэслэгч Д.Болормаа/-д тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн Хэлтсийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Алтансүх/-д даалгасугай.


ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



У.ЭНХТӨР

0522975

Санхүү, аж ахуйн албаны даргын
2017 оны 06 дугаар сарын 30-ны
өдрийн ... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВТОБААЗААС
ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБАД ШИЛЖҮҮЛЭХ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Материалын нэр	Ашиглалтанд орсон он	Нэг бүрийн үнэ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Дүн
1	Блок суурин /СП-4/	2009	50,000	ширхэг	66	3,300,000.00
Нийт дүн					66	3,300,000.00

САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБА

